



## ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН “БОР-ӨНДӨР” БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 11/13

Бор-Өндөр

### Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Боловсролын өрөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 04 дугаар тогтоолын 4 дэхь хэсэг, Хэнтий аймгийн Засаг даргын 2023 оны 628 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Бор-Өндөр” цогцолбор сургуулиас шилжүүлсэн 119 529 204 (нэг зуун арван есөн сая таван зуун хорин есөн мянга хоёр зуун дөрвөн) төгрөгийн балансын үнэтэй, хавсралтад дурдсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.
2. Хавсралтад дурдсан үндсэн хөрөнгийг холбогдох дүрэм журам, хууль тогтоомжийн дагуу бүртгэхийг нягтлан бодогч (Б.Анхчимэг), үндсэн хөрөнгийг бүртгэлжүүлэх, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг нярав (Ц.Туяацэцэг), өмч хамгаалах байнгын зөвлөл (Х.Хулан) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.АМАРЖАРГАЛ

